Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Иргэдээс 8 улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцох бүртгэл, 6 хувийн хэрэг хаах бүртгэлийн мэдүүлгийг хүлээн авч шийдвэрлүүлэхээр Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт хүргүүлснээс УБЕГазрын даргын тушаалаар 7 бүртгэл хүчингүйд тооцох, 4 хувийн хэрэг хаах тушаал гарч, өмчлөх эрхийн гэрчилгээг 11 өмчлөгчид хүлээлгэн өгсөн байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал гарахаар хүлээгдэж байгаа 3 бүртгэл байна.			
	Зарцуулсан хөрөнгө	Шаардлагагүй.			
	Хүрсэн түвшин	14 мэдүүлэг хүлээн авснаас 11 бүртгэлд тушаал гарч хэрэгжсэн. Хэрэгжилт-78,5%			
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	100 хувь	78,5%			

**УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА /ХЭУБ/**

**Гүйцэтгэлийн зорилт №3.4.1.** Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль:

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	3.4.1.1. Хуулийн этгээд шинээр болон өөрчлөн байгуулагдсаныг, хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг, хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсныг, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг, хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын дугаарыг, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавьсныг, цуцалсныг тус тус улсын бүртгэлд бүртгэх				
	Төлөвлөлтийн уялдаа:	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 2.3.1			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй			
	Хариуцах нэгж	Хуулийн этгээдийн улсын бүртгэгч			
	Суурь түвшин	2019 онд нийт 108 хуулийн этгээд шинээр байгуулагдаж, 166 хуулийн этгээд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд, татан буугдсан 8, хяналтын дугаар олгосон 139 , оноосон нэр баталгаажуулсан 135 бүртгүүлсэн.			
	Шалгуур үзүүлэлт	Хүлээн авсан бүртгэлийн тоо Хуулийн этгээдийн улсын бүртгэлд хуульд заасан хугацаанд бүртгэсэн тоо			
	Хүрэх түвшин	<b>Хагас болон жилийн эцэст:</b> Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг холбогдох хууль, журамд заасан хугацаанд үнэн зөв хөтөлсөн байна.			
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	2020 оны эхний хагас жилд шинээр байгуулагдсан-56, хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт-108, салбар төлөөлөгчийн газрын бүртгэл-12, хаягийн өөрчлөлт/шилжит хөдөлгөөн/-2, татан буугдсан-1, шинэ оноосон нэрийн хүсэлт-81, нэрийн өөрчлөлт-2, нэр сунгасан-2, хэлбэр өөрчилсөн-2, дахин гэрчилгээ олгосон-21, тамга тэмдэг хураан авсан-16, хяналтын дугаар олгосон-75, эцсийн өмчлөгч нөхөн бүртгэсэн-101, иргэн хуулийн этгээдэд лавлагаа хуулбар олгосон-155 бүртгэлийг бүртгэсэн байна.			
	Зарцуулсан хөрөнгө	Шаардахгүй.			
	Хүрсэн түвшин	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг холбогдох хууль, журамд заасан хугацаанд зөрчилгүй бүртгэсэн байна.			
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	100 хувь	100 хувь			

**Гүйцэтгэлийн зорилт №3.4.2.** Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Эрх зүйн акт: Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	2.2.1.2. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгэх				
	Төлөвлөлтийн уялдаа:	УБЕГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 3.4.3, УБЕГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2.1.2			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Батлагдсан төсвийн хүрээнд			
	Хариуцах нэгж	Хуулийн этгээдийн улсын бүртгэгч			
	Суурь түвшин	-			
	Шалгуур үзүүлэлт	1.Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авсан байх; 2.Хуульд заасан хугацаанд бүртгэсэн байх.			
	Хүрэх түвшин	<b>Хагас болон жилийн эцэст:</b> Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг улсын бүртгэлд бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийсэн байна.			
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Шинээр байгуулагдсаны-52, нэмэлт өөрчлөлт орсоны-105, хуульд заасан хугацаанд эцсийн өмчлөгчөө мэдүүлсний-62 нийт 269 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэсэн байна.			
	Зарцуулсан хөрөнгө	Шаардлагагүй.			
	Хүрсэн түвшин	Ковид-19 өвчинтэй холбоотойгоор эцсийн өмчлөгчийг бүртгэх ажил 15 хувьтай явагдаж байгаа бөгөөд үлдсэн хугацаанд нийт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгэх ажлыг арилжааны банкууд, татварын байгууллагатай хамтран зохион байгуулж дуусгана.			
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	100 хувь	15 хувь			

**Гүйцэтгэлийн зорилт №3.5.1.** Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль:

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	3.5.1.1. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар УБЕГ-аас гаргасан нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах				
	Төлөвлөлтийн уялдаа:	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 3.1.2			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй			

	Хариуцах нэгж	Иргэний бүртгэлийн тасаг
	Суурь түвшин	-
	Шалгуур үзүүлэлт	1.УИХ-ын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх Улсын бүртгэлийн ерөнхий газрын нарийвчилсан төлөвлөгөөний биелэлт хувиар
	Хүрэх түвшин	<b>Хагас болон жилийн эцэст:</b> Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлсэн байна.
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөт ажлын хүрээнд дараахь арга хэмжээг авч ажиллав.</p> <p>1. УБЕГазрын Мэдээлэл технологийн газраас тус аймгийн харьяалалтай нэг хаягт 10 ба түүнээс дээш сонгогч бүртгэгдсэн болон ижил овог нэртэй 433 иргэдийн мэдээллийн жагсаалтад Арвайхээр сумын 390, Хархорин сумын 43 иргэн байгааг холбогдох сумын улсын бүртгэгч нарт хүргүүлэн багийн Засаг дарга нартай хамтран мэдээллийг шалгаж, тодруулах ажлыг зохион байгуулж ажиллав.</p> <p>2. Мэдээлэл технологийн газраас тус аймгийн харьяалалтай байсан сонгуулийн насны хаяггүй 152 иргэний нэрсийн жагсаалт ирүүлснээс Арвайхээр сумын 70, бусад сумын 82 иргэн байсан байна. Сум дахь улсын бүртгэгч нарт багийн Засаг дарга, ажлын албадтай хамтарч тухайн иргэд, ар гэртэй нь холбогдон амьдарч буй газрыг тодруулах, хаягийн зөрчлийг арилгуулах хугацаатай мэдэгдэл өгч ажиллав. Үүнээс 106 иргэний хаягийг олж тогтоон, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийж, мэдээллийн санд хаягтай болгосон.</p> <p>3. Улсын ахлах бүртгэгч, иргэний улсын бүртгэгч нар нь election.mn систем рүү үүссэн эрхийн дагуу нэвтэрч санал авах байрны жагсаалт дээр 19 сумын ИТХТэргүүлэгчдийн тогтоолд заасан Өвөрхангай аймгийн 10 дугаар тойргийн 106 хэсгийн санал авах байрыг шинээр бүртгэж оруулав. Тухайн хэсгийн нутаг дэвсгэрт хамаарах /бүртгэлийн нэгжид хамаарах/ хаягийн жагсаалт бүхий цонхноос хаягийн мэдээллийг тус бүр нэмж оруулж баталгаажуулав. Мэдээлэл технологийн газраас хэсгийн дугаарлалт хийгдэж, хэсэг /10 дугаар тойргийн 10-1 дүгээр хэсгээс 10-106 дугаар хэсэг/ оноогдох 75683 иргэнд хэсгийн масс оноолт хийгдсэн байсан. Тус аймгийн /10 дугаар тойргийн / иргэдээс 179 иргэнд хэсэг оноолт хийгдээгүй байв. Үүнд Баян-Өндөр сумын 1 багийн 177, Хархорин сумын Эрдэнэтолгой багийн 2 иргэн байсан. 179 иргэнд хэсэг оноолтыг 2020 оны 03 дугаар сарын 27 нд хийж дуусгасан. Өвөрхангай аймгийн хэмжээнд 75862 иргэнд хэсэг оноолт хийгдэж дууссан. Тус системийн Хурлын тогтоол бүртгэх цэсийн Тогтоолын жагсаалтын- тогтоол нэмэх цонхоор 19 сумын ИТХТэргүүлэгчдийн тогтоолыг хавсралтын хамт файл болгон нэмж бүртгэв.</p> <p>4. Тус аймгийн 10 дугаар тойргийн 1-106 дугаар хэсгийн санал авах байрны жагсаалтыг нэг бүрчлэн дахин тулгалт нягтлав. 1-106 хэсгийн санал авах байранд оноогдох хаягийг /баг нийлсэн, баг хуваагдсан/ дахин шалгасан. Иргэний улсын нар сумын төвийн сонгуулийн насны иргэдийн нэрсийг жагсаалтаар багийн Засаг дарга нараас авч мэдээллийн санд хаяг, овог нэр, регистрийн дугаарын тулгалтыг хийсэн. Сонгогчдын нэрсийн жагсаалтад хэсэггүй</p>

		<p>Уянга сумын Өлтийн 7 дугаар багийн 1 сонгогч нэмэгдэж ирсэнийг хэсэг оноолт хийсэн. Хэлтсийн 70322937 утсанд сонгогчийн нэрсийн жагсаалттай холбоотой гомдол, санал ирээгүй. Улсын бүртгэлийн ерөнхий газрын холбогдох утсанд тус аймгийн харьяалалтай 5 иргэний /Уянга-2, Арвайхээр-2, Тарагт-1/ нэрсийн жагсаалт ирснийг мэдээллийг нь санд шалгах, сум хариуцсан улсын бүртгэгч нартай холбогдон тус хаягтаа байдаг эсэхийг тодруулсан. Мэдээллийн санд байгаа хаягаар хэсэг оноолт хийгдсэн байна. Сонгогчдын нэрсийн жагсаалт /10 тойрог 1-106 хэсэг, 75820 сонгогч/ зөрчилгүй байна. Сонгогч шилжих хөдөлгөөнтэй холбогдуулан сумын улсын улсын бүртгэгч нарыг өдөр тутамд арга зүйн удирдлагаар хангаж ажиллав. Сонгогч шилжих хөдөлгөөнийг 2020 оны 06 дугаар сарын 2-ноос эхэлж, 2020 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 00.00 цаг гэхэд дуусгасан.</p> <p>5.Итгэмжлэгдсэн ажилтнуудын судалгааг сумын ЗДТГазартай хамтран хийж, 106 хэсгийн хороонд ажиллах 106 итгэмжлэгдсэн ажилтан, 13 нөөцийн ажилтны судалгааг гарган аймаг дахь Тагнуулын хэлтэст хүргүүлсэн, Тагнуулын хэлтсээс ирсэн зөвшөөрлийн дагуу итгэмжлэгдсэн ажилтныг томилсон хэлтсийн даргын тушаал 2020.05.22-нд гарч, нууцын баталгаа авах, гэрээ хийгдэх, үнэмлэх олгох ажил зохион байгуулагдав.</p> <p>6.УИХ-ын сонгуулийн 10 дугаар тойргийн 106 хэсгийн хороонд ажиллах 118 итгэмжлэгдсэн ажилтны эрх зүйн сургалтын хөтөлбөрийн хэлтсийн даргаар батлуулан, итгэмжлэгдсэн ажилтнуудад цахимаар зохион байгуулав.</p> <p>7.Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны ирц бүртгэлийн программын сургалтыг зохион байгуулах ажлыг УБЕГазраас сургалтын багийнхантай хамтран зохион байгуулав. Сургалтыг 2020 оны 06 дугаар сарын 11,12 өдрүүдэд зохион байгуулж, 106 хэсгийн хороонд ажиллах 119 итгэмжлэгдсэн ажилтныг оролцуулав.</p> <p>8.Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх ажлын хэсгийг хэлтсийн даргын тушаалаар баталж, хэвлэх эрхийг иргэний улсын ахлах бүртгэгч, иргэний улсын 2 бүртгэгчид нээлгэв. Улсын Их Хурлын сонгуулийн 10 дугаар тойргийн 106 хэсгийн хороонд хаягтай СНЖагсаалтыг тус бүр 3 хувь үйлдэв. Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх үйл ажиллагаа 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 19 цаг 30 минутанд дууссан болно. Дээрх бүрэлдэхүүнийг байлцуулан 19 цаг 40 минутанд тус аймгийн 106 хэсгийн хорооны хэсгийн хороо тус бүрээр 3 хувь хэвлэсэн сонгогчийн нэрсийн жагсаалтыг тулган шалгаж, баталгаажуулах, битүүмжлэх ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулав. Сонгогчдын нэрийн жагсаалтыг УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн дагуу хэсгийн хороодод хүлээлгэн өгөх ажлын хэсгийг хэлтсийн даргаас томилж, маршрутыг батлан, 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 14.00 цагаас 3 чиглэлд гаргав. Арвайхээр сумын 13 хэсгийн хорооны дарга, итгэмжлэгдсэн ажилтан, сумын сонгуулийн хорооны дарга нарыг 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 11.00 уагаас хэлтсийн даргын 206 тоот өрөөнд ирүүлж, хэсгийн хороодод СНЖагсаалтыг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулав. Сум бүрт сумын сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарыг байлцуулан, хэсгийн хорооны дарга, итгэмжлэгдсэн ажилтанд тус бүр 1 хувь битүүмжлэл бүхий нэрийн жагсаалтыг хүлээлгэн өгч, хүлээцэх актыг 2 хувь үйлдэн 1 хувийг хэсгийн хорооны дарга нарт үлдээн нэг хувийг хэлтэст авч ирэв.18 сумын улсын бүртгэгч нарт чиглэл,</p>
--	--	--

		зааварчилгыг өгч ажиллав.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Шардлагагүй.
	<i>Хүрсэн түвшин</i>	Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар бүртгэлийн байгууллагын хүлээсэн үүрэг, бусад журмаар зохицуулагдсан үйл ажиллагаа ямар нэгэн зөрчил дутагдалгүй хийгдэж дууссан.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>	100 хувь	95 хувь

### УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ /БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ/

**Гүйцэтгэлийн зорилт №3.6.1.** Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах

Иргэнд чиглэсэн үйлчилгээ:

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>				
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	3.6.1.1. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, арилгах арга хэмжээ авах				
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 2.4.1			
<i>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</i>	<i>Хэрэгжих хугацаа</i>	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй			
	<i>Хариуцах нэгж</i>	Бүртгэлийн хяналтын улсын байцаагч			
	<i>Суурь түвшин</i>	2019 онд хяналтын улсын байцаагчийн 65 дүгнэлт үйлдэгдэж баталгаажсан. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-55, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр-5, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-5 дүгнэлт гаргаж зөрчлийг арилгасан.			
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд гарах зөрчлийг бууруулсан тоо			
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Хагас болон жилийн эцэст:</b> Улсын бүртгэлийн үйлчилгээ иргэн, хуулийн этгээдэд тэгш, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүрсэн байна.			
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт 2020 оны эхний хагас жилийн байдлаар 58 үйлдэгдсэн. Үүнд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 1579 иргэнд холбогдох 52 дүгнэлт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 4 дүгнэлт тус тус үйлдэж улсын бүртгэлийн хууль тогтоомжид нийцүүлэн бүртгэлийг зөрчлийг арилгаж ажилласан болно. Иргэний улсын бүртгэлийн зөрчлийг арилгах зорилгоор гарч байгаа дүгнэлтэд төрсний бүртгэлийг үндэслэн регистрийн дугаарыг өөрчилж дахин олгох дүгнэлт 11, иргэний үнэмлэх хүчингүй болгох 1425 иргэнд холбогдох 2, иргэний шинэчилсэн бүртгэлийн зөрчил 12 иргэнд холбогдох 3, бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 14, бүртгэл хүчингүй болгох 2 дүгнэлт тус тус оруулж баталгаажуулсан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар дүгнэлт хувийн хэрэг эх нотлох баримтаас зөрүүтэй			

		цахимжсан байгаа бүртгэлд дүгнэлт үйлдсэн байна.			
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Хөрөнгө шаардахгүй			
	<i>Хүрсэн түвшин</i>	Жилийн эцэст бүртгэлийн зөрчил арилсан байна.			
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>	100 хувь	100 хувь			
<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>				
Арга хэмжээний нэр, дугаар	3.6.1.2. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх				
	Төлөвлөлтийн уялдаа:	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 2.4.1			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй			
	<i>Хариуцах нэгж</i>	Бүртгэлийн хяналтын улсын байцаагч			
	<i>Суурь түвшин</i>	Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт <b>398</b> иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан <b>7,980,000</b> төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн			
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоогоор			
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Хагас болон жилийн эцэст:</b> Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо буурсан байна.			
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зөрчил шалган шийдвэрлэх харъяаллын дагуу мөн хуулийн 6.10 дахь хэсэгт улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэхээр харъяалуулсан зөрчлийг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, журамд нийцүүлэн шалган шийдвэрлэж байна. Эхний хагас жилийн байдлаар дээрх хууль тогтоомжийг зөрчсөн нийт 261 хүн хуулийн этгээдийн гаргасан зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 5.210.000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. Эхний хагас жилийн байдлаар зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн зөрчлийг 95 хувьд иргэний улсын бүртгэлийг тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй зөрчил байна.			
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Хөрөнгө шаардахгүй			
	<i>Хүрсэн түвшин</i>	Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчлийн илрүүлэлт нэмэгдсэн байна.			
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>	100 хувь	100 хувь			



**Гүйцэтгэлийн зорилт №3.6.2. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавих**

№	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>				
Арга хэмжээний нэр, дугаар	3.6.2.1. Сумдын улсын бүртгэгч нарын бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх.				
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 2.4.1			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Улсын төсөв			
	<i>Хариуцах нэгж</i>	Бүртгэлийн хяналтын улсын байцаагч			
	<i>Суурь түвшин</i>	2019 онд Хайрхандулаан, Өлзийт, Баянгол, Сант, Төгрөг, Гучин-Ус, Богд, Баруунбаян-Улаан сумын иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж 1319 иргэний улсын бүртгэлийг хянаж 28 зөрчил илрүүлж сумын улсын бүртгэгч нарт зөрчил арилган ажиллах хугацаатай албан шаардлага, улсын байцаагчийн мэдэгдлийг тус тус хүргүүлж бүртгэлийн зөрчлийг арилгуулсан.			
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	1.Шалгалт хийсэн сумын улсын бүртгэлийн тоо 2.Илрүүлсэн зөрчлийн тоо			
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Хагас болон жилийн эцэст:</b> Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгасан байна.			
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Тус аймагт 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 31-нийг хүртэлх иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт шалгалтыг хийлээ.</p> <p>Уг шалгалтан тус аймгийн 19 сумын 946 бүртгэлд хамрагдсанаас</p> <p>Нотлох баримтын бүрдүүлбэр хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгахад шилжин ирж байгаа иргэний хаягийн мэдээлэл үл хөдлөх эд хөрөнгийн хаягтай зөрсөн зөрчил 25 илэрсэн. Уг зөрчлийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим сан ePRS-д тулгаж шалгахад 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Аймгийн Иргэдийн хурлын тэргүүлэгчдийн 11 дүгээр тогтоолоор Арвайхээр сумын Зүлэг 12 баг, Онги 13 дугаар багуудын хаягийг зураг, барилга байгууламж, үл хөдлөх эд хөрөнгө, гэр хорооллын хаягийн жагсаалт батлах тухай тогтоолоор Арвайхээр 5 дугаар баг, Бурхи 9 дүгээр баг тус хуваагдсан билээ. Дээрх багуудийн иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийхдээ шинэчилсэн хаягаар бүртгэсэн боловч үл хөдлөх эд хөрөнгийн хуучин хаягтай гэрчилгээг хавсаргаж уг бүртгэлийг хийсэн зөрснийг шинэ кадастрын зургийг хавсарган бүртгэлийн зөрчлийг арилгасан болно.</p> <p>Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн сонгогчийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийн нотлох баримтын үнэн зөв, сонгогч шилжин явсан, шилжин ирсний бүртгэлд хууль журмын дагуу бүртгэгдсэн эсэх, сонгуулийн тойргийн хороо хэсгийн хорооны хэсэг оноолт үнэн зөв хийгдсэн зэрэг 1600 бүртгэлд хяналт шалгалт хийн уг бүртгэлд 5 зөрчил илэрснийг хяналтын улсын дүгнэлтээр зөрчлийг арилгасан.</p> <p>Тайлант хугацаанд Арвайхээр сумын иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх 362 бүртгэлд хяналт шалгалт хийсэн. Уг шалгалтаар 2</p>			



		бүртгэлд зөрчил илэрснийг газар дээр нь арилгуулж ажилласан.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлаггүй
	<i>Хүрсэн түвшин</i>	Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөнд тусгагдсны дагуу хяналт шалгалтыг бүрэн гүйцэт хийсэн байна.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>	100 хувь	

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>				
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	3.6.2.2.Иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, арилгах арга хэмжээ авах				
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 2.4.1			
<i>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</i>	<i>Хэрэгжих хугацаа</i>	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй			
	<i>Хариуцах нэгж</i>	Бүртгэлийн хяналтын улсын байцаагч			
	<i>Суурь түвшин</i>	2019 онд улсын бүртгэлийн нийт <b>2347</b> бүртгэлд хяналт шалгалт хийж 29 зөрчил илрүүлж арилгасан			
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	1.Хяналт шалгалт хийсэн бүртгэлийн тоо 2. Арилгасан зөрчлийн тоо			
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Хагас болон жилийн эцэст:</b> Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны явцад үүссэн зөрчлийг 100% арилгасан байна.			
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	Тус хэлтсийн 2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсны дагуу иргэний улсын бүртгэлийн 3554, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 58, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 50, нийт 3662 бүртгэл хяналт шалгалт хийснээс иргэний улсын бүртгэлийн 56, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 1, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 1 бүртгэлд зөрчил илэрч эдгээр зөрчлийг арилган ажилласан болно.			
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлаггүй			
	<i>Хүрсэн түвшин</i>	Зөрчил арилгаж шийдвэрлэсэн хувь-100%			
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>	100 хувь				

**УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА /УБ-ИЙН АРХИВ/**

**Гүйцэтгэлийн зорилт №3.7.1.** Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулах

Мэргэжилтэй ажилтанд чиглэсэн үйлчилгээ:

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	3.7.1.1. Иргэний баримтын архивын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлэн, тогтоосон хугацаанд баяжилт өөрчлөлт, сэлбэн засалтыг хийж, ашиглалт, хадгалалтанд хяналт тавьж ажиллана.				
	Төлөвлөлтийн уялдаа:	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 2.5.1			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй			
	Хариуцах нэгж	Иргэний бүртгэлийн тасаг, архивч			
	Суурь түвшин	2019 онд иргэний баримтын архивт нийт 15,262 ширхэг ИУБ маягтуудыг архивын санд байршуулснаас иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн 3997 , ИУБ-31 маягт 5531 , өөр аймаг, хотоос шилжиж ирсэн 544, иргэний үнэмлэх олголтын ИУБ-21 маягт 5190 байсан. Хувийн хэрэгжсэн сангийн 103 ширхэг хайрцагийг сэлбэн засаж нэр хаягийг шинээр бичиж шинэтгэсэн. 82 хадгаламжийн нэгж шинээр үүсгэсэн.			
	Шалгуур үзүүлэлт	Иргэний баримтын архивын сан тогтоосон хугацаанд баяжигдсан эсэх, архивын сэлбэн засалт хугацаандаа хийгдсэн эсэх, архивын баримт аюулгүй байдалд байгаа эсэх			
	Хүрэх түвшин	Иргэний баримтын архивын сан хөмрөг стандартын дагуу аюулгүй байдалд хадгалагдаж, баяжигдсан байна.			
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Тайлангийн хугацаанд нийт <b>8014</b> ширхэг ИУБ маягтуудыг архивын санд байршуулснаас иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн ИУБ маягтууд <b>1744</b> ширхэг, <b>хуулбар бүртгэлээр</b> хийсэн ИУБ маягт ИБТ-аас <b>47</b> , сумдын улсын бүртгэгч нар <b>402</b> хуулбар бүртгэлийг УБЕГ-т албан тоотоор хүргүүлж санд оруулсан байна. ИУБ-31 маягт <b>1866</b> ширхэг, ИУБ-21 маягт <b>2493</b> ширхэг, өөр аймаг, хотоос шилжиж ирсэн <b>1462</b> иргэний хувийн хэргийг тус тус байршуулсан байна. Аймагас гадагш шилжилт хөдөлгөөн хийлгэсэн <b>237</b> хүний холбогдох хувийн хэргийг архивын сангаас хайн олж, холбогдох газрууд руу хүргүүлсэн байна. Нийслэл болон аймаг хотуудаас шилжиж ирсэн <b>656</b> иргэний ИУБ-22 маягтыг холбогдох хувийн хэргийн хамт архивын санд байршуулаад байна. Мөн аймаг дотор шилжилт хөдөлгөөн хийлгэсэн нийт <b>1462</b> иргэний ИУБ-22 маягтыг архивын санд байршуулаад байна. Архивын сангаас зөрчилтэй нийт <b>1147</b> иргэний мэдээллийг татан авч шалгаснаас <b>1132</b> иргэний зөрчлийг арилгаж, буцаан байршуулсан байна. Зөрчил нь арилаагүй <b>15</b> иргэний хувийн хэрэг байршаагүй байна..			
	Зарцуулсан хөрөнгө	Шаардлагагүй.			

	<i>Хүрсэн түвшин</i>	Иргэний баримтын архивын үйл ажиллагаа хууль, журмын хүрээнд явагдаж байна. Албаны нууцын хадгалалт хамгаалалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>	100 хувь	100 хувь



**ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

/ ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ /

№	Үйлчилгээний төрөл	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ				Дундаж хувь
			%	%	%	%	
1.	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах	12					
2.	Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах	2					
3	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах	1					
4	Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх	2					
5	Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах	3					
Нийт		20					

**ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

**НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №1.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА**

**Гүйцэтгэлийн зорилт №4.1.1.Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	4.1.1.1.Хэлтсийн даргын Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж тайлагнах.				
	Төлөвлөлтийн уялдаа:	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 3.2.1			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй			
	Хариуцах нэгж	Хэлтсийн дарга			
	Суурь түвшин	2019 онд гүйцэтгэлийн төлөвлөгөө 88.9%-тай дүгнэгдсэн.			
	Шалгуур үзүүлэлт	1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулсан эсэх, 2. Гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлсэн эсэх			
	Хүрэх түвшин	<b>Хагас, бүтэн жилээр:</b> Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсан байх ба байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар гаргаж дээд газарт хүргүүлсэн байна.			
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Хэлтсийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хагас жилийн тайланг биелэлтийн хамтаар тогтоосон хугацаанд УБЕГ-т хүргүүлэн ажилласан.			
	Зарцуулсан хөрөнгө	Шаардлагагүй.			
	Хүрсэн түвшин	Тайлан , төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаандаа тайлагнасан.			
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	100 хувь	80 хувь			

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	4.1.1.2.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх				
	Төлөвлөлтийн уялдаа:	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 3.2.1			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй			

	<i>Хариуцах нэгж</i>	Бичиг хэргийн ажилтан
	<i>Суурь түвшин</i>	2019 онд тус хэлтэст нийт 117 өргөдөл гомдол бүртгэгдсэнийг шийдвэрлэж хариуг өгсөн. Хугацаа хоцорсон өргөдөл, гомдол байхгүй
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувиар
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Хагас болон жилийн эцэст:</b> Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, тайланг УБЕГ, аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	2020 оны 6 сарын 15-ны өдрийн байдлаар нийт 110 өргөдөл ирснээс иргэний бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 53, бүртгэл хяналтын үйл ажиллагаатай холбоотой 37, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 7, ЭХЭУБүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 1, ХЭУБүртгэлтэй холбоотой 1, бусад 11 байна. Шийдвэрлэсэн өргөдөл 95, хугацаа болоогүй шийдвэрлэх шатандаа байгаа 15.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Шаардлагагүй.
	<i>Хүрсэн түвшин</i>	Өмнөх оны мөн үеэс бүртгэлийн зөрчил буурсан байна. Гомдол гараагүй.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>	100 хувь	86.36 хувь

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>				
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	4.1.1.3.Улсын бүртгэлийн сар бүрийн тоо мэдээ, тайлан болон хийж хэрэгжүүлсэн томоохон ажлын тайланг дээд газарт хүргүүлэх				
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 3.2.1			
<i>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</i>	<i>Хэрэгжих хугацаа</i>	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй			
	<i>Хариуцах нэгж</i>	Хэлтсийн дарга, Бичиг хэргийн ажилтан			
	<i>Суурь түвшин</i>	2019 онд хугацаа хоцроосон мэдээ, тайлан байхгүй.			
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Заасан хугацааны дотор буюу сар бүрийн 25-ны өдрийн дотор тайланг холбогдох газруудад хүргүүлсэн эсэх.			
<i>Хүрэх түвшин</i>	<b>Хагас болон жилийн эцэст:</b> Тайлан хугацаандаа УБЕГгазарт болон аймгийн ЗДТГазарт хүргэгдсэн байна.				

Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Улсын бүртгэлтэй холбоотой сар бүрийн мэдээ тайланг тогтоосон хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна. Иргэний улсын бүртгэлийн газарт иргэний бүртгэл, мэдээллийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тоон мэдээг-6 удаа Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн сарын мэдээг-6 удаа. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хуулийн этгээдийн бүртгэлийн сарын мэдээг-6 удаа. Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газарт архивын үйл ажиллагааны тоон мэдээг -6 удаа, аймгийн ЗДТГазарт өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээг -2 удаа мөн хугацаатай мэдээ тайланг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. Тайлангийн хугацаанд аймагт хийсэн томоохон ажил нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 35 сая төгрөгийг шийдүүлэн автомашинтай болсон. Мөн хэлтсийн гаднах авто зам авто зогсоолын асуудлыг шийдвэрлүүлэн засвар үйлчилгээг орон нутгийн төсвөөр хийлгэсэн.
	Зарцуулсан хөрөнгө	35 сая, орон нутгийн хөрөнгөөр
	Хүрсэн түвшин	Мэдээ тайланг хугацаа хоцролгүй хүргүүлсэн. Хэлтэс авто машинтай болсон. Гадна авто замын зогсоолыг шийдвэрлэсэн.
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	100 хувь	100 хувь

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	4.1.1.4. 2020 онд зохион байгуулах хэлтсийн сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах				
	Төлөвлөлтийн уялдаа:	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 3.2.1			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилт тухай бүр зардал гардаг			
	Хариуцах нэгж	Сургалт хариуцсан ажилтан			
	Суурь түвшин	2019 онд дотоодын 3 сургалтанд, УБЕГ-аас зохион байгуулсан 9 удаагийн танхимын сургалтанд, 3 удаагийн онлайн сургалтанд, бусад байгууллага аймгийн ЗДТГ азраас зохион байгуулсан 4 удаагийн сургалтанд тус тус албан хаагчдыг хамруулж давхардсан тоогоор 98 албан хаагчдыг мэдлэг, ур чадвараа сайжруулах сургалтанд хамруулсан байна.			
	Шалгуур үзүүлэлт	1.Сургалтын төлөвлөгөө гаргасан эсэх 2.Зохион байгуулсан сургалтын тоо 3.Сургалтанд хамруулсан албан хаагчдын тоо			
	Хүрэх түвшин	<b>Хагас болон жилийн эцэст:</b> Төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдаж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна.			
Арга хэмжээний	Хэрэгжилт	Албан хаагчдын сургалт-хөгжил сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэлтсийн хэмжээнд шинэ ажлын байр шинэ			

<i>хэрэгжилт</i>		бүртгэгч сургалтанд 1 албан хаагчийг, Авилгын эсрэг хууль, сонгуулийн тухай хуулиар онлайн сургалт-2 удаа, танхимын сургалт-2 удаа зохион байгуулж алба хаагчид болон итгэмжлэгдсэн ажилтнуудыг хамрууллаа. УБЕГазраас зохион байгуулсан 17 удаагийн онлайн сургалтанд холбогдох алба хаагчид хамрагдсан.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	320,000 төг
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэлтсээс зохион байгуулсан сургалтын тоо-4. Хамрагдсан ажилтны тоо-266. УБЕГазраас зохион байгуулсан сургалтын тоо-17
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>	100 хувь	100 хувь

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>				
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	4.1.1.5. Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих				
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 3.2.1			
<i>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</i>	<i>Хэрэгжих хугацаа</i>	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй			
	<i>Хариуцах нэгж</i>	Хэлтсийн дарга, бичиг хэргийн ажилтан			
	<i>Суурь түвшин</i>	2019 онд хэлтэст нийт 1746 бичиг ирсэн ба 1311 албан бичиг явуулсныг тус тус албан бичгийн бүртгэлд бүртгэн дугаарлаж хяналтын карт хэвлэн холбогдох албан хаагчдад шилжүүлсэн. Нийт ирсэн бичгээс 688 нь хугацаатай, хариутай бичиг байсан.			
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	1.Баримт бичгийн эргэлтийн тоогоор 2.Хугацаатай хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувиар			
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Хагас болон жилийн эцэст:</b> Хэлтсийн албан хэрэг хөтлөлт стандартын дагуу явагдсан байна.			
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	2020 оны 5 сарын 31-ний өдрийн байдлаар хэлтэст нийт 928 бичиг ирсэн ба 694 албан бичиг явуулсныг тус тус албан бичгийн бүртгэл болон Able Cloud программд бүртгэсэн. Хариутай албан бичигт хяналтын карт хөтлөн холбогдох албан хаагчдад шилжүүлсэн. Нийт ирсэн бичгээс 383 нь хугацаатай, хариутай бичиг байсан. Мөн төрийн байгууллагын цахим шуудан болох email-ийг ашиглан мэдээлэл солилцон мэдээллийн сан үүсгэн лавлагаа, мэдээ тайланг хүлээн авах, яаралтай албан тоотыг хүргүүлэх, хүлээж авах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.			
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Шаардлагагүй.			
	<i>Хүрсэн түвшин</i>	Ирсэн бичиг 928, явсан бичиг 694, хариутай албан бичиг 383			
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>	100 хувь	100 хувь			

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	4.1.1.6.Байгууллагын БНШАЗК-ын үйл ажиллагаанд хяналт тавих, хэлтсийн 2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлын зохион байгуулах				
	Төлөөлөлтийн уялдаа:	УБЕГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө 3.2.1			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р у улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй			
	Хариуцах нэгж	Бичиг хэргийн ажилтан			
	Суурь түвшин	2018 оны байнга хадгалах 9 хадгаламжийн нэгж, түр халгалах 47 хадгаламжийн нэгжийг зохих журам, зааврын дагуу бүрдүүлэн байгууллагын архивт байршуулсан.			
	Шалгуур үзүүлэлт	Жагсаалтыг эцэслэн батлуулсан эсэх.			
	Хүрэх түвшин	<b>Хагас болон жилийн эцэст:</b> Жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.			
